3.1	Төрийн үзүүлдэг үйлчилгээг зорилгоор болон дотоодын төстэй байгууллагуудтай харилцаж холбоо тогтоох, туршилага сурлах, мөргөжилт, арга зүйн зөвлөмжөөр хангах	— сая төгрөг	Дотоодын нэгээс доошгүй байгууллагатай хамтран ажиллаж, харилцан туршилага солилцон ажилласан байх. Гадаадын ижил төстэй байгууллагын үйл ажиллагааг суралцаж ажиллас.	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар, орон нутгийн ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас туршилага суралцаж, харилцан ажилтай ажилладаг.	Дотоодын нэгээс доошгүй байгууллагатай шинээр харилцаа холбоо тогтоож, харилцан ажилтай хамтран ажилласан байх. Гадаад улсын ижил төстэй гурваас доошгүй байгууллагын үйл ажиллагааг судлан, мэдээллийн бааз үүсгэх	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Австри Улс, Белгийн Хант Улс, ОХУ зэрэг улсуудын "Баримта байгууламжийн засаар үйлчилгээний газар" төрийн өмчит байгууллагын үйл ажиллагааг интернэтээс судлах, туршилага судлан ажиллав. Улмаар нийтлэг үйлчилгээнд ашиглаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, давуу тал, шинэлэг арга туршилагаас нэвтрүүлэн ажиллалаа. Харин коронавируус (Covid-19) цар тахал болон Зөстийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох азалтыг баримтлан дотоодын нэгээс доошгүй байгууллагатай холбоо харилцаа тогтоон ажиллах нөхцөл хоригдсон учир хойшуулсан болно.	100% 100%
4	"Санхүү, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг удирдан ажиллах" зорилтын хүрээнд	6.1 тэрбум төгрөг	Орлогоороо санхүүжээ, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байх.	Өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажилладаг.	Хөрөнгө санхүүгийн хувьд үйл ажиллагаа хэвийн санхүүжүүлж ажилласан байх.	Үйлдвэрийн газар нь явуулсан үйл ажиллагаанаа үр дүнгээр өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлэн ажиллав. 2021 онд төвлөрүүлэх орлогыг өмнөх оны мөн үеэс 200 сая төгрөг буюу 4 хувиар өсгөн төвлөрүүлж ажилласан.	100% 100%
4.1	Төсөв төлөвлөгөөт төвлөрүүлж, үр ашгийг зарцуулж ажиллана.	6.1 тэрбум төгрөг	Өмнөх оны мөн үед олох орлогоос тухайн оны мөн үед олох орлогыг бууруулахгүй ажиллах.	2020 онд нийт 5,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	Орлогыг нэмэгдүүлж, зарцуулалтын ашгийг нэмэгдүүлсэн байх.	Тус үйлдвэрийн газар нь тухайн онд явуулсан үйл ажиллагааны орлогоороо санхүүжигдэн ажиллаж байна. 2021 онд 6,1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан.	100% 100%
4.2	Өмч хөрөнгийн менежментийг сайжруулан ажиллах	—	Өмчийн бүртгэл тооллого, хууль ашиглалтыг тогтоомжийн хүрээнд явуулсан байх	Эрх бүхий байгууллагаас 2020 онд өмчийн менежментийг үлгэр жишээ явуулсан гэж үнэлсэн	Төрийн өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, хийж ашиглалтыг сайжруулан, эд хөрөнгийн ямар нэг зорчилгүй ажилласан байх.	Урд онуудад хүрсэн түвшингээс бууруулахгүйгээр өмчийн менежментийг хэрэгжүүлж ажиллав. Тус онд цар тахлын дагдалт газар өвсөнтэй холбоотойгоор бараа материалын огдоц ховордох, үнэ өсөх нөхцөл бүрдсэн ч цаг үеийн нөхцөлд тааруулсан шийдвэр гаргаснаар хүндрэл бэрхшээлийг хохиrol багатай даван туулан ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх чанар, загвар, шаардлагад	100% 100%

4.3	Харьяа байруудад байрлах төрийн байгууллуудын байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний чиглэлээр улсын төсөвт тусуулан батлуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтын өмчийн тооцоо судалгааны төсвийн боловсруулж, тухайн байгууллуудад хүргүүлэн ажиглах	—	Харицагч байгууллагатай хамтран ажиглах болон орчууллагад шаардагдах хөрөнгийн талаар мэдээлэл хүргүүлж хамтран ажигласан эсэх	Харьяа байруудад байрлан ажилладаг төрийн байгууллуудад байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний ажлын чиглэлээр ирэх жилийн төсөвт ямар хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын ажил тусуулах шаардлагатай тухай саналыг хүргүүлж ирэх онд хэрхэн хамтран ажиглах талаар хэлэлцсэн байх.	Харьяа байруудад байрлан ажилладаг төрийн байгууллуудад байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний ажлын чиглэлээр ирэх жилийн төсөвт ямар хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын ажил тусуулах шаардлагатай тухай саналыг хүргүүлж ирэх онд хэрхэн хамтран ажиглах талаар хэлэлцсэн байх.	нийцсэн эд хөрөнгийг бүртгэн, салбан засаж сайжруулан, үргүй зардал гаргахгүй байх талаар анхаарч ажиглаа. Улмаар бараа материал, сабдж хэрэгслийн хадгалалт, төрөлжүүлэлт, цогцалтыг боловсронгуй болгож, балан байдлыг ханган ажиглав. 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар үндсэн хөрөнгийн 11,2 тэрбуа төгрөг, хангамжийн материалын 213,4 сая төгрөг, бараа материалын 278,9 сая төгрөгийн эд хөрөнгийн тус тус үлдэгдэлтэй байна. Харин үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 661,6 сая төгрөг, үндсэн хөрөнгийн худалдан авалт 87,8 сая төгрөг, хангамжийн материалын худалдан авалт 24,8 сая төгрөг, хангамжийн материалын зардал 22 сая төгрөг, бараа материалын худалдан авалт 808,4 сая төгрөг, бараа материалын зардал 5473,8 сая төгрөг тус тус байна.	100%
				Засгийн газрын байранд байрлах үйл ажиллагаа явуулж байгаа байр, байгууллуудын эзэмшиж байгаа байр, талбай, аач байгаа нийтлэг үйлчилгээний хэмжээнд ногдох зардлыг тухайн байгууллагын төсөвт суулган санхүүжүүлж байвар зохины дагуу 2022 оны улсын төсөвт тусуулах шаардлагатай байр ашиглалтын зардлын саналыг харицагч байгууллуудад 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 102-138 дугаар тоот албан бичиг, Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлийн газарт 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/106 тоот албан бичгээр мөн Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газарт 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/108 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Улмаар 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 225-259 тоот албан албан бичгээр "Ажил, нийтлэг үйлчилгээ гүйцэтгэх тухай гэрээ" байгуулсан			

							Байгууллагаудад тус албан тоотыг дараах журмулж ажигласан.	
--	--	--	--	--	--	--	--	--

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний
Хавсралт №1-ийн биелэлт.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ажилчдын 2021 оны
мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөний биелэлт

№	Сургалтын нэр	Сургалтын зорилго	Хугацаа	Хэрэгжилт
А	Нэг. Ажлын байран дахь сургалт			
1.	Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний эрх зүйн мэдлэг олгох сургалт, мэдээлэл, зөвлөгөө	Ажилтан, хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сахилга, даг журмыг сайжруулах	Жилдээ	Байгууллагын хууль, эрх зүй, гэрээ хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн нар харьяа байр тус бүр дээр очиж Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох асуудлаар мэдээлэл зөвлөгөөг нэгдүгээр улиралд өгч ажилласан. Мөн 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөх Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга болон байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж буй хууль, дүрэм, журам, тогтоол шийдвэрүүдийн нэгдсэн санг бэлтгэн, захиргааны ажилчдад сургалт, зөвлөгөө хийсэн. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн "Төрийн албаны шинэтгэлийн бодлого, шийдэл, цогц чадваржинд суурилсан хүний нөөцийн удирдлага" сэдэвт цуврал сургалтуудад захиргааны бүх ажилчдыг танхимын болон цахим хэлбэрээр оролцуулав. Хөдөлмөрийн хууль шинээр дагаж мөрдөгдөхтэй холбогдуулан байгууллагын хөдөлмөрийн дотоод журмд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.
2.	Ажлын байрны хөдөлмөр зохион байгуулалт /5S зарчим/	Ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах	II, IV улиралд	Ажилчдын ажлын байрны зохион байгуулалт, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, цэвэр цэмцгэр байдлыг тасралтгүй сайжруулах зорилгоор Стандарт, хэмжил зүйн газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо MNS ISO 45001:2018 стандартын сургалтанд цахим хэлбэрээр 11 ажилтан хамруулсан. Байгууллагын чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн 11 дүгээр сарын 18-ны өдөр "Ажлын байрны хөдөлмөр зохион байгуулалт" (5S зарчим)-ыг хэрэгжүүлэх, амх цэгцгийг сайжруулах нь сэдэвтэй сургалт хийх ажиллав.
3	Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэлт	Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай болгох	IV улирал	Байгууллагын эмч А.Оюудва 11 дүгээр сарын 08, 09, 10 өдөрүүдэд "Эмнэлгийн анхан шатны ларалтай тусламж"-ийг хэрхэн үзүүлэх, "Коронавирус халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, өвдсөн

				тохиолдолд бие махбодид юу тохиолддог вэ? сэдэвт сургалтыг халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан байгууллагын нийт ажилчдыг хамруулан зохион байгуулав. Засгийн газрын II, III байруудад ажилладаг эмч нар нийгэм цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж ажиллав. Мөн цахим хэлбэрээр бүх албан хаагчдад мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Байгууллагын санхүү, бүртгэлийн хэлтсийн ажилтнууд нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн хууль тогтоомж, цалинтай холбоотой мэдээлэл, сургалтыг нийт ажилтнуудад цахимаар болон ганцаарчилсан хэлбэрээр өгч ажилласан. Мөн 11 дүгээр сарын 18-ны өдөр хийгдсэн "Чанарын багийн өдөрлөг"-ийн үеэр Санхүү, бүртгэлийн ажилтнууд нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлстэй холбоотой мэдээллийг өгч ажилласан. Цэцэг, ногоон байгууламж хариуцсан ажилтан П.Эрдэнэбат 11 дүгээр сарын 11-ний өдөр "Тасалгааны болон мандалын цэцэг арчлах, дадлага туршлагыг сайжруулах, эрүүл ахуйг дээшлүүлэх" сэдэвт сургалтыг чанарын багийн ахлагч нарт хийсэн. Үүний үр дүнд харьяа байруудын албаны өрөө тасалгаан дахь цэцэг, ногоон байгууламжийг өөрсдөө тарьж, ургуулах чадвар нэмэгдэж байна. Технологийн хөгжил дэвшил, мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилготой сургалтыг мэдээлэл технологийн инженер Б.Баасанжавуу 11 дүгээр сарын 17-ны өдөр хийлгүүлэв. Байгууллагын техник тоног төхөөрөмжийг орчин үеийн дэвшилтэт хэрэгслэлээр шинэчлэн сайжруулснаар ажилчид техник технологийг ашиглах чадамж нэмэгдсэн. 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан "Чанарын өдөрлөг"-ийн арга хэмжээг зохион байгуулах үеэр бүх чанарын багуудын ажилтнуудад үйлчилгээний ёс зүй, Алтан дүрэм, Чанарын багийн үйл ажиллагааны талаар мэдлэг олгох сургалт, зөвлөгөөг өгч ажилласан. Чанарын багуудын ажилтнуудад "Харилцаа хандлага, зөрэг хандлага", "Алтан дүрэм" сэдвээр мэдлэг олгох сургалт, зөвлөгөөг өгч ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлага, үйлчилгээнд анхаарах зүйлс сэдвээр сургалт зохион байгуулан ажилласан.
4.	Нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн хууль тогтоомж, цалинтай холбоотой мэдээлэл, сургалт	Ажиллагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	I улирал	
5.	Цэцэг, ногоон байгууламжийн үйлчилгээ /хөмсний мод, тасалгааны цэцэг/	Ургамал арчлах арга, өрчилгээнд суралцах	4-5 сард	
6.	Технологийн дэвшил	Техник хөгжлийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болох	Жилдээ	
7.	Үйлчилгээний ажилтны ёс зүйн сургалт	Ажлын байрны соёл эзэмших сургалт	Улиралд	
8.	Нийтлэг үйлчилгээний ажилчдын зан харилцаа, ёс зүй, алтан дүрмийн талаар цуврал хичээл орох	Байгууллагын соёл, үйлчилгээний ажилтнуудын харилцааг дээшлүүлэх	Улиралд	
Б	Хоёр. Мэргэшүүлэх, дадлага эзэмшүүлэх сургалт			
1	Чанарын удирдлагын тогтолцооны зарчим, ач холбогдол,	Чанарын удирдлагын тогтолцооны онол, арга	II, III	Магадлах аудитыг жил бүр СХЗГ-ын баталгаажуулалтын газраар хийлгүүлж, амжилттай дүгнүүлж, гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмших

стандартчиллын тухай тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллах	зүйн мэдлэгийг бататгах	улиралд	эрх авч, аудитын мөрөөр сайжруулалтын ажлуудыг хангаж ажилласан.
2 Цацаг ногоон байгууламж арчлах, цацагжүүлэлтийн ажил хийх	Ургамал арчлах арга арчилгаанд суралцах	II, III улиралд	Засгийн газрын харьяа байруудын ерөө тасалгаан дахь 3145 ширхэг цэцгийг арчлан хамгаалж, шинээр нэмж 350 ширхэг цэцгийн вааран сав авч албан өрөө тасалгааны цэцгийн савыг жигдрүүлэх ажил хийв. Мөн 104 ширхэг мод, бут сөөгөнд шохойдолт хийж, тайрч засан, 1304 ширхэг мод, бут сөөгийг арчлан нөхөн сэргээв. Харын улиралд буюу 4, 5 дугаар сард гадна талын ногоон байгууламжийг цэвэрлэн 10 ширхэг гацуур мод болон 430 шар хуяйс тарьж, гадна талбайн 6379.5 м.кв ногоон байгууламжаас 4756 м.кв бүхий ногоон байгууламжийн талбайн зэрлэг ургамлыг устгаж, орчныг цэвэрлэн, ногоон байгууламжийн өнгө үзмэжийг сайжруулах зорилгоор өөс ногоог тэгшлэн хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн шинээр 1223 м.кв талбайд шинээр зүлэг тарьж, 134 ширхэг цэцгийн мандал зэргийг тус тус арчлан хамгаалж, ургуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Улмаар харьяа байрууд дээрх ажилтнуудад цэцэг, ногоон байгууламж хариуцсан ажилтан арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.
3 Гамшиг осол, галын аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зөвлөмж өгөх	Гамшиг осол, галын аюулгүй байдал хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх	I, III улиралд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх зорилгоор байгууллагын 11 ажилтан албан хаагч Стандарт, хэмжиг зүйн газрын сургалтанд хамрагдсан. Мөн "Амжилт боломж гарц" МСТ-д ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэшсэн ажилтны 40 цагийн сургалтанд 2 ажилтанг суралцуулснаар ажлын байранд дээрх хөдөлмөрийн аюулгүй байдлыг тодорхойлж, аюул ослоос урьдчилан сэргийлэн ажилласан.
4 Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах	Гамшиг осол, галын аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох, чадвар дадал суулгах	II улиралд	Гамшгийн үеийн дуут дохиогоор ажиллах тактикийн сургалт 2021 оны 03 дугаар сард улс орон даяар явагдах үеэр мэргэжлийн байгууллагаас хүний бөөгнөрөл үүсгэхгүй зохион байгуулах даалгавар өгсний дагуу яам, агентлаг, аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудыг аюулгүйн талбайд цуглуулахгүйгээр өрөөндөө "Суу, нуугд, хүлээ" гэсэн зарчмаар сургалт хийсэн.
5 Албан бичиг, архивын мэргэшсэн сургалт	Онол, арга зүйн мэдлэгийг бататгах	Жилдээ	Архивын ерөнхий газрын 2 өдрийн "Байгууллагын архивт баримт бичиг хүлээн авах, баримтанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлын арга зүй" сэдэвт сургалтанд 2 ажилтанг суралцуулсан.
6 Лифтний аюулгүй ажиллагааны төлөвлөгөөт сургалт /үнэмлэх сунгалт/	Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах	Жилдээ	Хүн болон ачаа зөөврийн лифттай байруудын техникийн аюулгүй байдал, өргөх тээвэрлэх машин механизмьг аюулгүй ашиглах, төхөөрөмжлөх, норм дүрмийг хангах зорилгоор сунгалтын хугацаа дууссан үед лифтын механикийг Механик инженерийн сургуулийн дэргэдэх "Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв"-ийн сургалтанд хамруулна.

7	Хөргөлт, агаар салгалтийн сургалт	Тонсг төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах	Жилдээ	Засгийн газрын харьяа байруудын халаах, хөргөх хэрэгслэлийн алдаа гэмтэл саатлыг түргэн шуурхай хэвийн олж илрүүлэн, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор сунгалтын хугацаа дууссан үед хөргөлт, агаар салгалтийн сургалтанд хамруулна.
В. Мэргэжил олгох сургалт				
	Мэргэшсэн сургалтанд хамруулах	Стандарт хэрэгжүүлэх, ажиллагчдад мэргэжил, дадал суулгах	Жилдээ	Харьяа дээд байгууллагын мэргэшсэн үйлчлэгчийн эрх олгох сургалтанд 22 үйлчлэгч хамрагдан мэргэшсэн үйлчлэгчийн үнэмлэхтэй болсон.
Г. Дөрөв. Сургалтанд үзүүлэх бусад дэмжлэг				
1	Ажлын хажуугаар суралцах боломжийг хангах үүднээс ажлын хуваарийг өөрчлөх, чөлөө олгох	Ажилтны нийгмийн баталгааг хангахад туслах	Жилдээ	Удирдлагын академийн магистрын ангид Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 3 ажилтан, мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд 1 нягтлан бодогч, мэргэшсэн инженерийн сургалтанд 1 инженер, мэргэшүүлэх сургалтын төвийн сургалтанд хамрагдсан техникийн ажилтнуудад ажлын ачааллаас нь хамааруулан хуваарийг өөрчлөх бусад ажилчид орлон гүйцэтгэх замаар тус сургалтуудад чөлөө олгон суралцуулав.
2	Шинэ ажилтныг дадлагажуулах буюу чиглүүлэх сургалтууд	Ажлын байрны дадлагажуулж, арга барил эзэмшүүлэх	Жилдээ	Шинээр ажилд орж буй үйлчлэгч, техникийн ажилчдад чанарын багийн ажлагч болон мэргэшсэн үйлчлэгч нар ажлын байрны тодорхойлолтонд заагдсан чиг үүргийг гүйцэтгэхэд ажлын байранд дадлагажуулан, арга барилыг эзэмшүүлж чиглүүлэн ажилладаг.
3	Чанарын багуудын тэргүүн туршлагыг солбилцуулах, нэвтрүүлэх	Тэргүүн туршлага нэвтрүүлэх, багийн ажлыг идэвхжүүлэх	Жилдээ	2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Чанарын өдөрлөг"-ийн арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Чанарын өдөрлөгөөр ISO 9001:2016 стандартын хэрэгжилт, Чанарын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх бодлого, үйл ажиллагааг мэдээлэх, үйлчилгээний стандартыг хангаж ажиллах, ажилчдын идэвх, санаачилгыг өрнүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан.
Сургалтын нийт зардал: 13,3 сая төгрөг				

“Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлт

Хэрэгжүүлэх хөтөлбөрийн төрөл	Агуулга	Хэрэгжүүлэх үндэслэл	Төрөл
1. Ажилтан, ажиллагчдыг ажиллах нөхцөлөөр хангах:	1.1. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйл, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.2.3 дахь заалт.	Техникийн ажилчид болон үйлчлэгч нарын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон багажны хайрцаг, тасдагч, хамгаалах малгай, тусгай түлхүүр, шат, цохилттой дринль, тоос сорогчны филтэр, мананцар үүсгэгч ариутгалын буу зэрэг багаж хэрэгслийг тухай бүрт нь сольж, шинэчлэн ажиллав. Бүх албан хаагчдад коронавирус (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор супер гар ариутгагч, амны хаалт (маск-боодол), нэг удаагийн бээлий (хайрцаг), нүүрний хаалт, витамин D3 (4000 тунтай-нэг хайрцаг), цагаан идээний багц (5 кг аарц, 200 грамм шар тос, 300 грамм ааруул) зэргийг олгов. Техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах зорилгоор харьяа байруудын хяналтын камерны төхөөрөмжинд нэмж хард диск 8 ширхэг, NVR камерын бичигч төхөөрөмж 2 ширхэгийг тус тус авч суурилуулснаар нийт 7,1 сая төгрөгийг зарцуулсан. Ажилчдын утасны аппарат 8 ширхэгийг 439,200 төгрөгөөр шинээр авч бэлэн байдлыг ханган ажилласан. Мөн коронавирус (Ковид-19) цар тахалт өвчний улмаас байгууллагын ажилчид цахим хэлбэрээр ажиллах шаардлага тулгарсан тул вэб камер болон чихэвчийн хамт тус бүр 33 ширхэгийг худалдан авсан. Үүнд: 3.2 сая төгрөг зарцуулсан.
2. Нийгмийн баталгааг хангах	2.1. Хоол, унааны хөнгөлөлт үзүүлнэ. 2.2. Орон байраар хангах, амьдрах нөхцөлийг нь сайжруулах	Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.5 дахь заалт Төсвийн тухай хуулийн 46.4 дэх хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.3.5 дахь заалт.	2021 оны 10 дугаар сарын цалин олголтоос эхлэн нэг ажилтны хоол унааны хөнгөлөлтийг 2000 төгрөгөөр нэмэгдүүлэн ажлын нэг өдөрт 6000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. 2021 онд хоол унааны хөнгөлөлийг давхардсан тоогоор 2938 ажилтанд олгоход 148,9 сая төгрөг зарцуулсан. Зорилтот бүлгийн иргэдийг төрөөс орон сууцны төсөлд хамруулах хөтөлбөрт байгууллагын албан хаагч А хүсэлт гаргасныг холбогдох байгууллагад уламжилсан бөгөөд тухайн иргэний амьдралын нөхцөлийг судлан үзсэнээр олон зуун иргэнээс 108 дугаарт буюу дээгүүрт эрэмбэлэгдсэн.

			Мөн өрх толгойлсон, амьдралын нөхцөл хүндэд тооцогдох үйлчлэгч Ж.Энхтуулын тусламж хүссэн өргөдөл, захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Б/154 тоот тушаалаар 2,7 сая төгрөгийн үнэ бүхий өргөө цагаан гэрийг гардуулан өгөв. *Амжилт боломж гарц* мэргэжил сургалтын төвийн 40 цагийн ХАБЭА-н сургалтанд хоёр ажилтанг сургахад 500, мянган төгрөг зарцуулав. Стандарт, хэмжил зүйн газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх зорилготой сургалтанд байгууллагын 11 ажилтан албан хаагчийг, мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд 1 нягтлан бодогчийг тус тус хамруулахад 1,2 сая төгрөг зарцуулсан. Архивын ерөнхий газрын хоёр өдрийн "Байгууллагын архивт баримт бичиг хүлээн авах, баримтанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлын арга зүй" сэдэвт сургалтанд хоёр ажилтанг хамруулахад 100 мянган төгрөг зарцуулав. Удирдлагын академид хоёр албан хаагч суралцуулахад төлбөрийн зохих хэсэгт дэмжлэг үзүүлэхэд 2.9 сая төгрөг, Худалдаа үйлдвэрийн дээд сургуулийг мэргэжлийн дагуу төгсөж буй ажилтанд 1.9 төгрөгийн сургалтын төлбөрийг тус тус олгож ажиллав. Ажил мэргэжлийнхээ чиглэлээр мэргэжил дээшлүүлэх зорилгоор сургууль, сургалтанд хамрагдаж буй ажиллагчдад ажлын байрны ачааллыг нь тохируулан, өөр бусад ажилтнаар орлуулан гүйцэтгэх арга барилаар чөлөө олгон суралцуулж байна. Тусламж, тэтгэмж хүссэн 85 өргөдөл, хүсэлт ирүүлснээс, ар гэрт нь гачигдал гарсан 24 ажилтанд 6,2 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийг тус тус олгов. Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан ажил албан тушаалыг хэвээр хадгалах тухай заалтыг чанд мөрдөн ажиллаж байна. Мөн Короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан ажил, албан тушаалыг хэвээр хадгалах бодлогыг баримтлан ажиллав.
	2.3. Сургалтын төлбөр олгох	Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг.	
3. Нэмэгдэл баталгаа	3.1. Ажил албан тушаалыг хэвээр хадгалах.	Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйл	

	3.2. Ажилтан, албан хаагчдад үзүүлэх хөнгөлөлт	Засгийн газрын "Төрийн албан хаагчид тусламж олгох тухай" 2004 оны 112 дугаар тогтоол	Түлээ нүүрсний нөхөн олговорт 163 ажилчид хамрагдаж нийт 12,9 сая төгрөг зарцуулагдсан. Мөн байгууллагын ажилтнуудын нийгмийн тулгамдаж буй асуудлаар судалгааг авч боловсруулан байгууллагын захирлын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/16 тоот тушаалаар ЗГБНУГ-ын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах тусгай хөтөлбөр (2020-2022 он)-ийг боловсруулан мөрдөн, хэрэгжүүлэн ажиллаж байна.
4. Цалин хөлс	4.1. Албан тушаалын цалин, мэргэшлийн зэрэг цол, үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгох	Засгийн газрын "Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох тухай" 2019 оны 382 дугаар тогтоол, Засгийн газрын "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын тогтоол;	Ажилтан, албан хаагчдын үр чадварын нэмэгдлийг ажил үүргээ мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэдэг, бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл шинийг санаачлан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн бол үр чадварын нэмэгдлийг 10-25 хувиар олгохоор шийдвэрлэж, 49 ажилтанд 39,9 сая төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон. Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолтой холбоотойгоор хагас, бүтэн жилийн үр дүнгийн урамшуулал олгох боломжгүй болсон ч байгууллагын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 263 ажилчдад 100,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгийг олгосон.
5. Ахмадын дэмжлэг	5.1. Тэтгэвэр тогтоолгох 5.2. Тус байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд тусламж олгох	Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.3.12 дахь заалт. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль 8.5 дахь заалт	Байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 5 ажилтанд 6 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний мөнгийг Захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэн олгосон. Үүнд нийт 19,8 сая төгрөг зарцуулсан. Монгол түмний уламжлалт баяр "Цагаан сар"-аар нэг ахмад настанд 50,000 төгрөгийн гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлэн нийт 98 ахмадад 4,9 сая төгрөг зарцуулав. Олон Улсын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан тус байгууллагад үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн 100 ахмад буурлууддаа нийгэм цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан дархлаа дэмжих цагаан идээний (5 кг аарц, 200 грамм шар тос, 300 грамм ааруул) багцыг бэлтгэн өгөв.
6. Тэтгэмж, тусламж	6.1. Албан хаагчийн гэр бүлд гачигдал тохиолдвол тусламж олгох	Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.3.3 дахь заалт.	Ар гэрт нь гачигдал гарсан 24 ажилтанд нийлбэр дүнгээр 6,2 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэн.

7. Шагнал урамшил	7.1. Мөнгөн шагнал олгох	Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчдад шагнал, урамшил олгох журам", Засгийн газрын 2004 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох журам"	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох зүйл заалттай холбоотойгоор мөнгөн шагнал урамшил олгогдох ажил хийгдэх боломжгүйд хүрсэн.
8. Эрүүл мэнд	7.2. Төрийн дээд байгууллага болон Засгийн газрын шагналд тодорхойлох 8.1. Эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамрагдах, үйлчилгээ авах	Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал урамшил олгох журам" Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйл	Байгууллагад үр бүтээлтэй, өндөр амжилт гаргасан ажилчдад төрийн дээд шагнал "Алтангадас" одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, салбарын тэргүүн, жуух бичгээр шагнуулах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэв. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг хоёр удаа коронавируст (Ковид-19) цар тахлын ЛПСР-ийн шинжилгээнд бүрэн хамруулсан. Улмаар төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгт вакцинжуулалтын ажлыг зохион байгуулан нийт ажилчдыг I, II тунгийн вакцинжуулалтанд хамруулсан. Мөн байгууллагын эмчээр "Коронавирус халдвар (Ковид-19)-ын дараах эмчилгээ болон бие махбодид юу тохиолддог вэ?" сэдэвт сургалтыг 3 өдрийн турш нийт ажилчдад мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Коронавирус (Ковид-19) цар тахлын аюулыг бууруулах үүднээс албан хаагчдыг шаардлагатай үед түргэвчилсэн шинжилгээнд хамруулах ажлыг байгууллагын эмчээр хийлгэн ажиллав. Улмаар Коронавирус хувьсалд орж вакцины бүүстэр тун буюу гуравдагч өдөөгч тунг албан ёсны эрх бүхий байгууллагуудын шийдвэрийн дагуу сайн дурын үндсэн дээр хийлгэх ажилд байгууллагын 256 ажилчдын 180 ажилчид буюу 70 хувь нь хамрагдсан. Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Засгийн газрын XI байрны подвалд байрлах фитнесийн өрөөний тоног төхөөрөмжийг сайжруулж, фитнесээр хичээллэхэд таатай нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн спорт зааланд их засварын ажил хийж тохижуулсан.